УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙН УЛМААС ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/209

2024.09.25


| | |
|---|---|
| Захиалагч: | УИХ-ЫН ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ |
| Хянасан: | Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь |
| Судалгаа удирдсан: | Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ахлах зөвлөх, эрдэмтэн нарийн бичгийн дарга Ц.Норовдондог (Ph.D.) |
| Судлаачид: | Р.Нургүл, Б.Мөнгөнсувд, П.Уранчимэг |



УЛААНБААТАР
2024 он

# АГУУЛГА

УДИРТГАЛ....2
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ....3
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ....7
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙН УЛМААС ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА....7
НЭГ. ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА....7
ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА....11
1. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс....11
2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс....13
3. Бүгд Найрамдах Казахстан Улс....15
4. Япон Улс....16
Ашигласан эх сурвалж....19

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс ирүүлсэн захиалгын дагуу “Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учруулсан хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: бусад орнуудын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэлээ.

***Судалгааны хамрах хүрээ:*** Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн сэдвийн хүрээнд Герман, Япон зэрэг ром-германы эрх зүйн системтэй хөгжингүй орнуудын туршлагыг, хөгжиж буй орнуудаас мөн адил эрх зүйн системд хамаарах Вьетнам, Казахстан зэрэг орнуудын туршлагыг авч үзлээ. Эдгээр орнуудын туршлагыг тухайн асуудлыг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзсэн болно.

***Судалгааны бүтэц*:** Судалгааны тайлан дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Олон улсын чиг хандлага
2. Гадаад орнуудын туршлага

***Түлхүүр үг*:** *хүний эрх; төр иргэнийхээ өмнө хүлээх хариуцлага; иргэн, аж ахуйн нэгжид төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх*

***Keywords*:** *human right; responsibility and duty of state; rights of recovery; rights to demand of recovery of loss; recover the loss incurred to them caused due to illegal action or inaction of the administrative body*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Аливаа улсын иргэн, аж ахуйн нэгжид төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлыг төрөөр нөхөн төлүүлэх, эрхийг сэргээн эдлүүлэх асуудал нь хүний эрхийн салшгүй нэг хэсэг бөгөөд энэхүү асуудлыг олон улсын түвшинд хамгаалан зохицуулсан байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас гаргасан "Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал" (The Universal Declaration of Human Rights)[1], "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт" (International Covenant on Civil and Political Rights)[2] зэрэг баримт бичгүүдэд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээсэн байдаг. Тиймээс НҮБ-ын гишүүн улс орнуудын төрөөс Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэнд учирсан гэм хор, хохирлыг иргэнийхээ өмнө хариуцан арилгах, нөхөн төлбөр олгох, эрхийг нь сэргээн хамгаалах зохицуулалтыг тусгасан байдаг.

Төрийн байгууллага, албан тушаалтан хууль бус шийдвэр гаргах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл хариуцлагагүй үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжийг хохироох тохиолдол практикт гардаг. Энэ тохиолдолд хохирлыг шууд (эд хөрөнгө, орлого гэх мэт) болон шууд бус хохирол (нэр хүнд, бизнесийн боломж, амгалан тайван байдал гэх мэт) гэж ангилахаас гадна санхүүгийн, эдийн засгийн, нийгмийн гэх мэтчилэн төрөлжүүлэн ангилдаг.

Дэлхийн улс орнууд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг нөхөн төлөх, хохирогчийн эрхийг хамгаалах асуудлыг Үндсэн хуулийн түвшинд баталгаажуулж, улмаар зарим оронд төрийн албаны, иргэний, захиргааны хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулдаг нийтлэг туршлага байдаг бол зарим оронд үүнийг тусгайлсан хуулиар зохицуулж байна. Түүнчлэн процессын шинжтэй нарийвчилсан харилцааг Засгийн газрын шийдвэр болон бусад холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулж байна. Ийнхүү зохицуулах нь төрийн байгууллагуудын хариуцлагыг тодорхой болгож, иргэн, аж ахуй нэгжийн эрхийг хамгаалах зорилготой.

**Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:**

Судалгаанд авагдсан 4 орны хувьд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан барагдуулах тухай үзэл санаа, мөн хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг төрөөс нөхөн төлөх үүргийг Үндсэн хуульдаа тусгаж баталгаажуулсан байна. Эдгээр орнуудаас Вьетнам, Япон зэрэг орнууд тухайн асуудлыг зохицуулсан тусгайлсан хуультай байгаа бол Герман, Казахстан зэрэг орнууд холбогдох хууль, эрх зүйн актуудаар зохицуулж байна.

**Вьетнам Улс**

Вьетнам Улс нь Төрийн нөхөн төлбөрийн хариуцлагын тухай хууль (On State compensation liabilty law)[3] гэх тусгайлсан хуультай бөгөөд энэ хуулиар төрийн байгууллагын удирдлага, хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, байгууллагад учирсан хохирлыг төрөөс барагдуулах; нөхөн олговор олгох журам; хохирол учирсан хувь хүн, байгууллагын эрх, үүрэг; нөхөн олговрын сан болон хохирол учруулсан албан тушаалтанд авах арга хэмжээ зэрэг асуудлыг зохицуулдаг. Эд материалын болон сэтгэл санааны хохирол амссан хувь хүн,

[1] Хүний эрхийн түгээмэл тунхаглал, https://legalinfo.mn/mn/detail/1271
[2] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, https://legalinfo.mn/mn/detail/1257
[3] On State compensation liabilty law, https://www.moj.gov.vn/vbpq/en/lists/vn%20bn%20php%20lut/view_detail.aspx?itemid=10465

байгууллага энэ хуульд заасны дагуу төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байх ба тухайн байгууллага буруутай албан тушаалтантай хариуцлага тооцох зарчимтай байна.

Түүнчлэн Хууль зүйн яамны харьяа Төрийн нөхөн олговрын газар (The State Compensation Department)[4] ажилладаг бөгөөд тус газар нь Төрийн нөхөн төлбөрийн хариуцлагын тухай хуулийн хэрэгжилт, нөхөн олговрын улмаас төрд үүсэж буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, төрөөс нөхөн олговор авах хүсэлтэй хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжид туслах, Хууль зүйн сайдад зөвлөн туслах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

**Герман Улс**

Герман Улс хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх эрх, үүргийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан байдаг. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль, Иргэний хууль болон холбогдох хууль, эрх зүйн актаар уг асуудлыг зохицуулж байна.

Герман Улс нь дайны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон, хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн, цэргийн алба хаах хугацаандаа бэртэж гэмтсэн, вакцинжуулалтын улмаас эрүүл мэндээрээ хохирсон гэх мэт төрийн үйл ажиллагааны улмаас хохирол амссан хохирогчид болон тэдний ар гэрт төрөөс нөхөн олговор олгох үндэсний тогтолцоог бий болгосон байна.

**Казахстан Улс**

Казахстан Улсад төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид хохирол учирсан тохиолдолд нөхөн төлөх асуудлыг Үндсэн хууль, Иргэний хууль, Захиргааны хэргийн хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн актаар зохицуулж байна. Эдгээр зохицуулалт нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус, буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх, иргэний эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлөх механизмыг бий болгоход чиглэгддэг.

Хохирлыг барагдуулахдаа шүүхэд гаргасан нэхэмжлэл, энэ хүрээнд шүүхээс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх**;** төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрийг хянах, үнэлэх механизмыг хэрэгжүүлэх**;** буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох**;** эрүүгийн болон иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх**;** иргэдийг мэдээ, мэдээллээр хангах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Хохирол барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээлүүд тулгардаг бөгөөд үүнд, авлига**,** шүүхийн системийн ачаалал**,** мэдээлэл дутмаг байх, төрийн байгууллагуудын хариуцлагагүй байдал, хууль зүйн үйлчилгээний хүртээмж, хууль тогтоомжийн тодорхойгүй байдал, нийгмийн сэтгэлгээ зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг байна.

**Япон Улс**

Япон Улсын Үндсэн хуульд хүн бүр төрийн албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг тусгасан байх бөгөөд түүнийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн нөхөн төлбөрийн тухай хууль (State Redress Act)[5]-ийг баталжээ. Хуульд зааснаар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа бусдад санаатай буюу санамсаргүй байдлаар хохирол учруулсан бол нөхөн төлөх үүрэгтэй байна. Мөн төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа санаатай буюу илт болгоомжгүй үйлдэл гаргасан бол төрийн болон олон нийтийн байгууллага нь төрийн албан хаагчаас нөхөн төлбөр гаргуулах эрхтэй байхаар заасан. Энэ хуулиас гадна

[4] https://thuvienphapluat.vn/van-ban/EN/Tai-chinh-nha-nuoc/Circular-no-03-2013-TT-BTP-guidelines-for-the-state-management-on-compensation/173965/tieng-anh.aspx
[5] State Redress Act, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3785/en#je_at2

Иргэний хууль болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор энэхүү асуудлыг зохицуулж байна.

**Монгол Улсын туршлага**

Монгол Улсад уг асуудлыг Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актаар зохицуулж байна. Эдгээр хуульд дараах зохицуулалтыг тусгажээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын иргэн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, … эрхтэй.";
- Захиргааны ерөнхий хуулийн **101.1-д** "Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна.", **101.2-д** "Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна.", **104.1**-д "Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна."
- Иргэний хуулийн 498.2-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана."
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.6-д "Захиргааны үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарч хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасан байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.5-д "Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас хуулийн этгээдэд учирсан хохирлыг энэ бүлэгт заасан журмын дагуу төр хариуцна."
- Төрийн албаны тухай хуулийн 50.1-д "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." гэж тус тус зохицуулсан байна.

**Хүснэгт 1. Монгол Улс болон судалгаанд авагдсан орнуудын төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг нөхөн төлөх эрх зүйн орчны хүрээ**

| | |
|---|---|
| Монгол | - Монгол Улсын Үндсэн хууль<br>- Захиргааны ерөнхий хууль<br>- Иргэний хууль<br>- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<br>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<br>- Төрийн албаны тухай хууль |
| Вьетнам | - Үндсэн хууль<br>- Төрийн нөхөн төлбөрийн хариуцлагын тухай хууль (On State compensation liabilty law) |
| Герман | - Үндсэн хууль |

| | |
|---|---|
| | - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль<br>- Иргэний хууль |
| Казахстан | - Үндсэн хууль<br>- Иргэний хууль<br>- Захиргааны хэргийн хууль<br>- Төрийн албаны тухай<br>- Холбогдох бусад |
| Япон | - Үндсэн хууль<br>- Төрийн нөхөн төлбөрийн тухай хууль<br>- Иргэний хууль<br>- Төрийн албаны хууль тогтоомж |

(Дэлгэрэнгүй мэдээллийг СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ хэсгээс үзнэ үү)

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙН УЛМААС ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

### НЭГ. ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Аливаа улсын иргэн, аж ахуйн нэгжийн төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас өөрт учирсан хохирлыг төрөөр нөхөн төлүүлэх эрхийн тухай асуудал нь хүний эрхийн салшгүй нэг хэсэг бөгөөд түүнийг олон улсын түвшинд дараах байдлаар хамгаалан зохицуулсан байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас гаргасан “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал” (The Universal Declaration of Human Rights)[6], “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” (International Covenant on Civil and Political Rights)[7], мөн улс орнуудын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хуулиар хүлээсэн байдаг.

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал” нь хүний үндсэн эрхийг эрхэмлэн дээдлэх зарчмыг баталсан баримт бичиг бөгөөд түүгээр хүний эрхийн баталгааны зорилт, суурь хэмжүүрийг олон улсын хэмжээнд анх удаагаа зарлан тунхаглажээ. Энэ нь олон улсын харилцаанд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны гол үндсэн эх сурвалж болдог.

Тунхаглалын 8 дугаар зүйлд, “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” байхаар суурь зохицуулалтыг заасан. Мөн НҮБ-аас гаргасан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-д (International Covenant on Civil and Political Rights)[8] төр иргэнийхээ эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээх үүргийг хариуцахаар тусгасан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал”[9]-д “төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй. Тухайн хохирлыг хариуцах Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна” хэмээн төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг иргэд нэхэмжлэх эрхийг баталгаажуулж, төр хохирлыг барагдуулах хариуцлагын механизмыг тунхагласан байдаг. Мөн тус тогтоолын хавсралт болох “Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчим”-д хохирогчид үзүүлэх туслалцааны асуудлыг “Хохирогч нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн болон бусад тусламжийн талаар мэдээлэл авах, тэдгээр үйлчилгээ, тусламжийг хүртэх ёстой. Хохирогчид тусламж үзүүлэх, үйлчлэхдээ тийнхүү учирсан хохирлын шинж байдалд тохируулахад анхаарал хандуулах хэрэгтэй” гэж тус тус заасан нь төр иргэдийнхээ өмнө учруулсан хохирлоо нөхөн барагдуулах бодлого

[6] 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг баталсан бөгөөд гишүүн улсууд “дэлхийн бүх улс түмэн, бүх улс гүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзвэл зохих нийтлэг зорилт болгон дэвшүүлж”, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг уриалсан.
[7] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор батлаж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон), https://legalinfo.mn/mn/detail/1257
[8] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор батлаж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон), https://legalinfo.mn/mn/detail/1257
[9] Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power, 1985., https://www.unodc.org/pdf/rddb/CCPCJ/1985/A-RES-40-34.pdf

баримтлахаас гадна, сурталчлан таниулж, хохирогчдын мэдээлэл авах эрхийг хангах ёстой талаар тусгасан байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр гаргах, үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл хариуцлагагүй үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид хохирол учруулах нөхцөл бий болдог. Хохирлыг шууд (жишээ нь, эд хөрөнгө, орлого гэх мэт) болон шууд бус хохирол (жишээ нь, нэр хүнд, бизнесийн боломж гэх мэт) гэж ангилдаг. Түүнээс гадна дараах төрөлд хувааж үздэг. Үүнд:

- Санхүүгийн хохирол: Төрийн байгууллагаас гаргасан хууль бус шийдвэрийн улмаас иргэн, аж ахуйн нэгжийн орлого, хөрөнгөд учирсан алдагдал зэрэг орно.
- Эдийн засгийн хохирол: Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь саатсан, зогссон, эсхүл хязгаарлагдсан тохиолдолд үүссэн хохирол орно.
- Нийгмийн хохирол: Үүнд иргэдийн нийгмийн эрх, эрх чөлөөг зөрчиж, тэдний амьдралд үзүүлсэн сөрөг нөлөө орно.

Хохирлыг нөхөн төлөх нь төрийн хариуцлагын нэг хэсэг бөгөөд энэ нь хууль, эрх зүйн актаар зохицуулагддаг.

### Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт

Иргэн, аж ахуйн нэгжид хохирол учруулсан бол төр иргэнийхээ өмнө хариуцлага хүлээх үзэл санаа, нөхөн төлөх асуудал болон хохирогчийн эрхийг улс орнууд Үндсэн хуулийн түвшинд хамгаалж баталгаажуулсан байдаг. Түүнээс гадна уг асуудлыг төрийн албаны хууль, иргэний хууль, захиргааны хууль, мөн төрийн болон орон нутгийн өмчийн тухай, гэмт хэрэг, зөрчил, хохирлын тухай болон хууль зүйн туслалцааны тухай хуулиудаар зохицуулдаг нийтлэг туршлага байна. Эдгээрээс гадна Хятад, Вьетнам зэрэг зарим оронд тусгайлсан хуулиар зохицуулж байна. Түүнчлэн нарийвчилсан харилцааг Засгийн газрын шийдвэр болон бусад холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулдаг. Ийнхүү зохицуулах нь төрийн байгууллагуудын хариуцлагыг тогтоож, иргэн, аж ахуй нэгжийн эрхийг хамгаалах зорилготой байна.

Хохирол нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ улс орнууд дараах нийтлэг туршлагыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- **Захиргааны хариуцлага**: Дэлхийн улс орнууд төрийн байгууллага, албан тушаалтандаа хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авдаг бөгөөд түүний дагуу иргэн, аж ахуйн нэгжид хохирол учруулсан төрийн байгууллага нь хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээдэг.
- **Төрийн хариуцлагын хууль**: Зарим улс тусгайлсан хуультай бөгөөд энэ нь иргэн, аж ахуйн нэгжид төрийн байгууллагаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжийг олгодог.
- **Шүүхийн практик**: Олон улс оронд хохирогч этгээд хуульд заасан хугацаандаа шүүхэд хандаж, хохирлоо нөхөн төлүүлэх хүсэлт гаргах боломжтой. Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэлтэй холбоотой шүүхийн шийдвэрүүд нь цаашид ийм төрлийн хэрэг шийдвэрлэхэд нөлөөлдөг байна.
- **Олон улсын эрх зүйн зохицуулалт**: Олон улсын эрх зүй, ялангуяа хүний эрхийг хамгаалах тухай олон улсын гэрээнүүдэд заасны дагуу төрийн байгууллага, албан тушаалтны үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ба үүнд байгууллагын болон улс орнуудын хариуцлагыг зохицуулсан байдаг.

- **Мэдлэг, мэдээлэл олгох**: Олон улсын практикт хохирогчид өөрсдийн эрхээ хамгаалах, хууль зүйн тусламж авах талаар мэдээлэлтэй байх нь чухал гэж үздэг. Тиймээс улс орнууд иргэдээ хууль зүйн боловсролтой болгох, давж заалдах эрхийн талаар мэдлэг, мэдээллээр хангах арга хэмжээ авч байна.

### Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус бууруутай үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг тодорхойлох

Олон улсын практикт төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг тодорхойлохдоо хэд хэдэн үндсэн зарчим баримталдаг. Үүнд:

1. **Хохирлыг тодорхойлох:** Хохирлыг үнэлэх үед уг үйлдэл нь хэрхэн хууль зөрчсөн, хохирогчид ямар төрлийн хохирол учирсан (материал, сэтгэл зүйн, алдагдал г.м.) гэдэгт анхаарал хандуулдаг. Хохирол нь шууд болон шууд бус, мөн эдийн засгийн болон сэтгэл зүйн байх боломжтой.
2. **Хариуцлагыг тогтоох:** Төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлагыг тогтоохдоо тухайн хүний үйлдэл нь хууль зөрчсөн эсэх, хохирогчид учруулсан хохирол нь уг үйлдлээс шалтгаалж байгаа эсэхийг шалгадаг.
3. **Нөхөн төлбөрийн зарчмууд:** Хохирогчдод нөхөн төлбөр олгохдоо тухайн хохирлын хэмжээг тодорхойлох, олговол зохих хэмжээг тооцоолох болон хохирогчийн түүх, өмнөх байдал болон бусад хүчин зүйлсийг харгалзан үздэг. Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо хохирогчийн эдийн засгийн алдагдал, сэтгэл санааны хохирол, ирээдүйн орлогын алдагдал зэргийг тооцдог.
4. **Шүүхийн шийдвэр:** Хохирогчид хохирлоо нөхөн төлүүлэхийн тулд шүүхэд хандах боломжтой. Шүүх нь хохирогчийн гомдлыг хүлээн авч, хохирлыг үнэлж, нөхөн төлбөрийн хэмжээ, хариуцлагыг тогтоох шийдвэр гаргана.
5. **Олон улсын эрх зүйн зохицуулалт:** Олон улсын хэмжээнд төрийн хариуцлагын асуудалд олон улсын гэрээ, конвенц, хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд (жишээлбэл, хүний эрхийн гэрээ) чухал үүрэгтэй байдаг.

Эдгээр зарчмууд нь тухайн улсын онцлогоос хамааран өөр өөр байж болно.

### Иргэн, аж ахуйн нэгжид хохирол учруулсан төрийн байгууллага, албан тушаалтанд авах арга хэмжээ

Иргэн, аж ахуйн нэгжид хохирол учруулсан төрийн байгууллага, албан тушаалтанд авах арга хэмжээ нь тухайн улсын хууль, эрх зүйн зохицуулалтаар тодорхойлогддог бөгөөд олон улсын практикт дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- **Сахилгын арга хэмжээ авах:** Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу албан тушаалтанд ял шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах гэх мэт;
- **Хэрэг үүсгэх:** Хууль зөрчсөн тохиолдолд мөрдөн шалгах, гэмт хэрэг үүсгэх замаар эрүүгийн хариуцлага тооцох;
- **Нөхөн төлүүлэх:** Хуульд заасан журмын дагуу хохирол учруулсан төрийн байгууллага, албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлэх;
- **Хохирогчийн шүүхэд гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх:** Иргэд болон аж ахуйн нэгжүүд хохирлоо нөхөн төлүүлэхийн тулд шүүхэд нэхэмжлэл гаргах, гомдол гаргах замаар шийдүүлэх;
- **Төрийн хяналт, аудит:** Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, аудит хийх замаар хариуцлага тооцох зэрэг болно.

Эдгээр арга хэмжээ нь иргэн, аж ахуйн нэгжид хохирол учруулсан төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох, хууль эрх зүйн зохицуулалтыг сахиулах зорилготой байдаг.

### Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ хохирлын хэмжээг тогтоох

Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ хохирлын хэмжээг тогтоох нь дараах хэд хэдэн алхамтай байдаг.

1. **Хохирлыг тодорхойлох**: Хохирлыг тогтоох хүрээнд шууд хохирол (жишээ нь, эд хөрөнгө, орлого) болон шууд бус хохирол (жишээ нь, нэр хүнд, бизнесийн боломж)-ыг тогтооно.
2. **Баримт нотолгоо цуглуулах**: Хохирол тогтоохын тулд хохирогч хохирлын хэмжээг нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, санхүүгийн тайлан, гэрээ, акт зэргийг цуглуулах шаардлагатай.
3. **Хохирлын хэмжээг тооцох**: Хохирлын хэмжээг тооцохдоо хохирогчийн алдагдсан боломжийн орлого, зардал, эд хөрөнгийн үнэ цэнэ, хохирлын улмаас учирсан бусад нөлөөллийг харгалзан үздэг.
4. **Шүүхэд хандах**: Хохирлын хэмжээг тогтоосны дараа хохирогч нь шүүхэд хандаж, хохирлоо нөхөн төлүүлэх хүсэлт гаргах боломжтой.

Олон улсын практикт эдгээр алхмуудыг дагаж, хохирлын хэмжээг тогтоох нь хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэхэд чухал үүрэгтэй гэж үздэг.

Төрийн байгууллага, албан тушаалтны  хууль зөрчсөн үйлдэл, иргэн, аж ахуйн нэгжид учруулж буй хохирлын шинж байдал нь ихэнхдээ Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг зөрчсөн шинжтэй байдаг байна.

## ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

### 1. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс (Вьетнам Улс) нь Бүгд найрамдах засаглалтай, Вьетнамын Үндэсний Ассамблей нь төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага бөгөөд бүх нийтийн санал асуулгаар 5 жилийн хугацаатай сонгогдсон 498 депутатаас бүрдсэн нэг танхимтай парламенттай учраас Монгол Улстай засаглалын хувьд төстэй гэж үзэн судалгаанд хамруулсан.

Одоогийн баримталж буй ***Үндсэн хуулийг*** 1992 онд баталсан.[10] Үндсэн хуулиар төрийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд ажилчин, тариачин, сэхээтэн ангиас бүрдэнэ; төр нь ард түмнийг бүх салбарт дэмжиж, эх орон, ард түмний эрх ашгийг зөрчсөн үйлдлийг хатуу шийтгэж, нийгэмд шударга ёс тогтоох, эрх чөлөөг дээдлэх, аз жаргалыг эдлүүлэх бүх нөхцөлийг хангасан баян, хүчирхэг улсыг байгуулахыг эрмэлзэнэ гэжээ. Төр нь бүх үндэстний тэгш байдал, эв нэгдэл, харилцан туслалцах бодлогыг баримталж, үндэсний ялгаварлан гадуурхах, хагалан бутаргах үйлдлийг хориглодог. Төрийн бүх байгууллага, албан хаагчид ард түмэндээ хүндэтгэлтэй хандаж, үнэнчээр үйлчилж, тэдэнтэй нягт холбоотой байж, санал бодлыг нь сонсох ёстой. Хүнд суртал, бардам зан, дураараа авирлах, авлига хээл хахуулыг эрс эсэргүүцнэ. Төрийн ашиг сонирхол, хамт олон, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бүх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ гэж Үндсэн хуульдаа заасан байна.

Хуулийн V бүлэгт иргэний үндсэн эрх, үүргийг заажээ. Иргэний эрх нь үүрэгтэйгээ салшгүй холбоотой. Төр нь иргэний эрхийг баталгаажуулдаг, иргэн нь төр, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. Иргэн төрийг удирдах, нийгмийг удирдах, улс орон, бүс нутгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд оролцох эрхтэй; тэрээр төрийн байгууллагуудад өргөдөл гаргаж, төрөөс зохион байгуулж буй бүх нийтийн санал асуулгад санал өгөх эрхтэй. Иргэн төрийн байгууллага, аж ахуйн нэгж, нийгмийн байгууллага, ардын зэвсэгт хүчний анги, хувь хүний хууль бус үйлдлийн эсрэг төрийн эрх бүхий байгууллагад гомдол гаргах, эсэргүүцэх эрхтэй. Гомдол, эсэргүүцлийг төрийн байгууллага хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэнэ. Төрийн ашиг сонирхол, хамт олон, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоож цаг тухайд нь хатуу арга хэмжээ авна. Хохирол гэмтэл учирсан этгээд, учирсан эд материалын хохирлыг нөхөн төлүүлж, нэр төрөө сэргээлгэх эрхтэй. Хуулийн өмнө иргэн бүр тэгш эрхтэй; иргэн хуулиар тогтоосон эрх чөлөөг эдэлнэ гэж тус тус заасан байна.

#### Төрийн нөхөн олговрын газар

Вьетнам Улсын Хууль зүйн яамны харьяанд Төрийн нөхөн олговрын газар (The State Compensation Department)[11] бие даасан байгууллагын статустай ажилладаг. Тус байгууллага нь Төрийн нөхөн төлбөрийн хариуцлагын тухай хуулийн хэрэгжилт, нөхөн олговрын улмаас төрд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, төрөөс нөхөн олговор авах хүсэлтэй хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжид туслах, Хууль зүйн сайдад зөвлөн туслах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

#### Төрийн нөхөн төлбөрийн хариуцлагын тухай хууль

Төрийн нөхөн төлбөрийн хариуцлагын тухай хууль (On State compensation liabilty law)[12]-ийг 2009 онд баталсан, 8 бүлэг, 67 зүйлтэй. Хуулийн зорилго нь аливаа төрийн байгууллагын удирдлага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын

[10] Constitution, https://www.moj.gov.vn/vbpq/en/Lists/Vn%20bn%20php%20lut/View_Detail.aspx?ItemID=10450
[11] https://thuvienphapluat.vn/van-ban/EN/Tai-chinh-nha-nuoc/Circular-no-03-2013-TT-BTP-guidelines-for-the-state-management-on-compensation/173965/tieng-anh.aspx
[12] On State compensation liabilty law, https://www.moj.gov.vn/vbpq/en/lists/vn%20bn%20php%20lut/view_detail.aspx?itemid=10465

албан хаагчдын буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, байгууллагад учирсан хохирлыг төрөөс барагдуулах; нөхөн олговор олгох журам; хохирол учирсан хувь хүн, байгууллагын эрх, үүрэг; нөхөн олговрын сан болон хохирол учруулсан албан тушаалтнаас нөхөн төлбөрийг гаргуулан авах зэрэг асуудлыг зохицуулдаг.

Эд материалын болон сэтгэл санааны хохирол амссан хувь хүн, байгууллага энэ хуульд заасны дагуу төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй. Нөхөн төлбөрийг дараах тохиолдолд шаардах эрхтэй.

- Албан үүрэг гүйцэтгэгчдийн (official-duty performer)[13] үйлдэл нь хууль бус болохыг нотлох баримттай, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий байгууллагаас тухайн этгээдийг хохироосон нь баримтаар тогтоогдсон тохиолдолд нөхөн олговор олгохыг шаардах эрхтэй;
- Хохирогч нь гомдол гаргах, захиргааны хэрэг үүсгэх явцад гомдлоо барагдуулахыг эрх бүхий этгээдээс шаардах, эсхүл шүүхэд нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах эрхтэй.

### Хохирол тооцох журам

Иргэн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэлд нөхөн төлбөр нэхэмжлэгчийн овог нэр, нөхөн төлбөр нэхэмжлэх болсон шалтгаан, хохирол болон нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой мэдээллийг багтаана. Нэхэмжлэлд албан үүрэг гүйцэтгэгчийн хууль бус үйлдлийг нотолсон баримт, нөхөн төлбөртэй холбоотой баримт, нотлох баримтыг тус тус хавсаргана.

Хохирлыг нөхөн төлөх тухай асуудлыг уг хуулийн 5 дугаар бүлэгт заасан байна. Үүнд:

1. Эд хөрөнгийн маргааны улмаас учирсан хохирол
2. Бодит орлогоо алдсан, орлого буурсны улмаас учирсан хохирол
3. Сэтгэл санааны хохирол
4. Хохирогч нас барсны улмаас учирсан хохирол
5. Эд хөрөнгийн буцаалт
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хохирогчийн нэр төрийг сэргээх асуудал.

### Нөхөн төлбөрийн сан, төлбөрийн журам

Төрийн төв болон орон нутгийн байгууллагууд нөхөн төлбөр олгох үүрэгтэй бөгөөд нөхөн олговрын санг төвлөрсөн төсөв, орон нутгийн төсвөөс бүрдүүлнэ. Бүх шатны байгууллагууд нөхөн төлбөрийн сангийн тооцоог тухайн жилийн өмнөх оны бодит нөхөн олговрын хэмжээтэй уялдуулан тооцоолж, эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж жил бүрийн төсөвт тусгуулах асуудлыг шийдвэрлүүлнэ.

Нөхөн төлбөр олгох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 хоногийн дотор нөхөн төлбөрийн нэхэмжлэлтэй холбоотой материалыг холбогдох байгууллагад шилжүүлнэ. Баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор материал хүлээн авсан байгууллага нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн баримт бичгийг шалгаж, нөхөн төлбөр олгох тохиолдолд хүсэлтийг холбогдох санхүүгийн байгууллагад илгээнэ. Баримт бичгийг шалгах явцад уг баримт бичгийн бүрдлийг хянаж, нэмэлт баримт, материал шаардах эрхтэй. Баримт бичгийн нэмэлт бүрдүүлэлтийн хугацаа нь 15 хоногоос хэтрэхгүй байна. Нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 10 хоногийн

[13] On State compensation liabilty law, Article.3.1. An official-duty performer means a person who is elected, approved, recruited or appointed to a position in a state agency to perform the tasks of administrative management, legal proceedings or judgment enforcement, or a person who is assigned by a competent state agency to perform tasks related to administrative management. legal proceedings or judgment enforcement

дотор эрх бүхий санхүүгийн байгууллагаас нөхөн төлбөрт олгох хөрөнгийг хариуцагч байгууллагад хуваарилна. Нөхөн төлбөр хариуцагч байгууллага санхүүгийн байгууллагаас хуваарилсан хөрөнгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хохирогч, тэдгээрийн ар гэрт олгох үүрэгтэй.

### Нөхөн төлбөр олгосны хариуцлага

Хохирол учруулсан гэм буруутай албан тушаалтан хохирсон хүмүүст нөхөн төлбөр болгон олгосон мөнгөн дүнг эрх бүхий бүхий байгууллагын шийдвэрээр улсын төсөвт эргүүлэн төлөх үүрэгтэй. Эрх бүхий байгууллага нь гэм буруутай албан тушаалтнаас мөнгөн дүнг гаргуулан авахаас гадна гаргасан зөрчлийн шинж чанар, нөхцөлөөс хамаарч хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах, хариуцлага хүлээлгэх үүрэгтэй.

Нөхөн төлбөр төлүүлэх шийдвэр гаргах эрх нь байгууллагын даргад байна. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн асуудлаар гомдол гаргаж, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Хохирол учруулсан албан тушаалтан энэ шийдвэрийн талаар гомдол гаргаагүй, шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол нөхөн төлүүлэх шийдвэрт гарын үсэг зурснаас хойш 15 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Нөхөн төлбөрийг бөөнд нь, эсхүл хэсэгчлэн төлж болно. Албан тушаалтны сарын цалингаас үе шаттайгаар нөхөн төлбөрийг суутгах ба суутгалын доод хэмжээ 10 хувиас багагүй, дээд хэмжээ 30 хувиас ихгүй байна.

## 2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман Улс)-д тус асуудлыг Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулж байна.

Герман Улс нь дайнд хөгжлийн бэрхшээлтэй болсон, хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн, цэргийн алба хаах хугацаандаа бэртэж гэмтсэн, вакцинжуулалтын улмаас эрүүл мэндээрээ хохирсон гэх мэт төрийн үйл ажиллагааны улмаас хохирол амссан хохирогчид болон тэдний ар гэрт төрөөс нөхөн олговор олгох үндэсний тогтолцоог бэхжүүлсэн байдаг. Тухайлбал, тус улсын Үндсэн хуулиар хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх эрх үүргийг хуульчлан зохицуулсан байдаг.

Тус улс нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны улмаас учирсан гэм хор, хохирлыг төр хариуцан арилгах тухай үзэл санааг Үндсэн хуулийн түвшинд хуульчлан зохицуулсан байдаг. Төрөөс нөхөн олговор олгох үндэсний тогтолцоог хэд хэдэн хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, Үндсэн хууль, Иргэний хууль, Холбооны Улсын дайны хохирогчийн тэтгэмжийн тухай хууль, Холбооны Улсын нөхөн олговрын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль, Нийгмийн нөхөн олговрын тухай хууль, Хохирогчийн нөхөн олговрын тухай хууль, Хохирогчийн нөхөн төлбөрийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг байна.

### Германы Үндсэн хууль

Үндсэн хуулийн 34 дүгээр зүйл[14]

“… төрийн албан хаагч нь өөрт итгэмжлэн хүлээлгэсэн ажил үүргийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн бол үүнтэй холбоотой учирсан хохирлыг төр хариуцан арилгана” гэж заасан байдаг. Түүнчлэн Холбооны Үндсэн Хуулийн Шүүх нь Үндсэн хуульд заасан хохирогчийн үндсэн эрхийг хамгаалах, тэдний эрх ашгийг шүүхийн журмаар хамгаалах, бататгахыг  төрд үүрэг болгох эрхтэй.

[14] Basic Law for the Federal Republic of Germany, https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html#p0172

### Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйл.[15]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас хохирол учирсан этгээд нь тухайн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл ял оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон зэрэг бусад байдлаар дуусгавар болгосон тохиолдолд төрийн сангаас хохирол нэхэмжлэх эрхтэй.

### Германы Иргэний хууль

**Иргэний хуулийн 280 дугаар зүйл**. Хохирол нөхөн төлөх үүрэг

1. Хүлээсэн үүргээ зөрчсөн хариуцагч иргэнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. Тухайн хариуцагч нь иргэнд учирсан хохиролд хариуцлага хүлээхээргүй бол энэ заалт хамаарахгүй.
2. Энэ хуулийн 286 дугаар зүйлд заасан нэмэлт шаардлагын дагуу иргэн хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.
3. Хохирсон иргэн энэ хуулийн 281, 282, 283 дугаар зүйлд заасан нэмэлт шаардлагын дагуу хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.

**Иргэний хуулийн 34 дүгээр зүйл**

Хэрэв аливаа этгээд өөрт нь олгогдсон төрийн албан үүргээ зөрчсөн бол түүний хариуцлагыг төр, эсхүл түүнийг ажиллуулж байгаа байгууллага зарчмын хувьд хариуцна.

**Иргэний хуулийн 839 дүгээр зүйл.** Албан үүргээ зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага[16]

- Төрийн албан хаагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан үүргээ санаатай болон санамсаргүй байдлаар зөрчсөн бол тэрхүү үйлдлийн улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн албан хаагч хариуцан барагдуулах үүрэгтэй. Хэрэв тухайн албан хаагч хайхрамжгүй хандсан бол хохирсон иргэнд нөхөн төлбөр өгч чадахгүй тохиолдолд хариуцлага хүлээнэ.
- Албан тушаалтны гэмт хэргийн шинжтэй хууль бус үйлдлээс үүсэх гэм хорыг тухайн албан тушаалтан өөрөө бүрэн хариуцна. Энэ заалт албан үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн, татгалзсан болон хэтрүүлсэн бусад тохиолдолд хамаарахгүй.
- Хохирогч санаатай, эсхүл санамсаргүй байдлаар учруулсан гэм хорыг арилгуулахаар хуулийн байгууллагад гомдол гаргаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэхгүй.

Энэ хуулийн 839 дүгээр зүйлийг 34 дүгээр зүйлтэй хамтатган хэрэглэх нь дараах хүрээгээр хязгаарлагдана. Үүнд:

- Тухайн зөрчил нь заавал төрийн албан хаагчийн үйлдлийн үр дүн байх;
- Тухайн маргаантай үйлдэл нь албан хаагчийн өөрт нь олгогдсон албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой байх;
- Учруулсан гэм хор нь зөрчигдсөн хэм хэмжээгээр хамгаалагдсан хүрээнд байх;
- Тухайн зөрчил нь санаатай болон болгоомжгүй байдлаар үйлдэгдсэн байх.[17]

[15] Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG), https://www.gesetze-im-internet.de/streg/BJNR001570971.html
[16] Bürgerliches Gesetzbuch (BGB), § 839 Haftung bei Amtspflichtverletzung, https://www.gesetze-im-internet.de/bgb/__839.html
[17] Хохирлын сангийн тухай гадаад орнуудын харьцуулсан судалгаа., 181 дүгээр тал., Хууль зүйн үндэсний хүрээлэн.

## 3. Бүгд Найрамдах Казахстан Улс

### Бүгд Найрамдах Казахстан Улс (Казахстан Улс)-ын төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учруулсан хохирлыг нөхөн төлөхтэй холбоотой зохицуулалтууд

Казахстан Улсад төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн албаны хууль, Захиргааны хэргийн тухай хууль зэрэг хуулиудаар голлон зохицуулсан байна. Эдгээрээс гадна холбогдох бусад хууль, эрх зүйн актуудын хүрээнд зарим асуудлыг зохицуулдаг.

**Үндсэн хуульд**[18] хүн бүрийн эрх, эрх чөлөөг хамгаалахаар заасан байна.

**Казахстаны Иргэний хууль:**[19] Энэ хуулиар хохирол барагдуулахтай холбоотой үндсэн зарчмуудыг тодорхойлсон. Тухайлбал, хохирлын хэмжээг тодорхойлж, хохирол барагдуулах зарчмуудыг тусгасан байна.

**Төрийн албаны хууль:**[20] Албан тушаалтны үйл ажиллагааны хариуцлага, тэдгээрийн хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх эрх, үүргийг зохицуулдаг. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа хууль бус гэж тогтоогдвол уг шийдвэрийг хүчингүй болгох, хохирлыг нөхөн төлүүлэх журмын зохицуулалтыг тусгасан байна.

**Захиргааны хэргийн тухай хууль:**[21] Захиргааны шийдвэрийн хууль бус байдал, түүний улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг нөхөн төлөх зохицуулалтыг тусгасан.

**Эрүүгийн хууль**[22]**:** Хулгай, авлига, хүнд гэмт хэргийн улмаас хохирол учирсан тохиолдолд хариуцлага тооцох, хохирлыг барагдуулах механизмуудыг тодорхойлсон.

Эдгээр зохицуулалт нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус, буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх, иргэн, аж ахуйн нэгжийн эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлөх механизмыг бүрдүүлдэг.

### Эдгээр зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

Казахстан Улсын хууль эрх зүйн системд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг барагдуулах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Захиргааны хяналт: Төрийн байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрийг хянах, үнэлэх механизмыг хэрэгжүүлдэг. Энэ нь хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд уг шийдвэрийг хүчингүй болгох, буруутай этгээдэд хариуцлага тооцож, хохирлыг нөхөн төлүүлэх боломж олгоно.
- Хэрэг үүсгэж мөрдөн шалгах: Төрийн албан тушаалтны хууль бус үйлдлийг мөрдөн шалгах, хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, хэрэв хохирол учирсан бол хохирогчийн эрхийг хамгаалахын тулд хуулийн арга хэмжээ авч болно.
- Иргэний эрх зүйн хариуцлага: Иргэн, аж ахуйн нэгж хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй бөгөөд иргэний хуульд заасны дагуу хохирогч нь хохирлоо тодорхойлуулах, баримтжуулах, шүүхэд хандах эрхтэй.

[18] Қазақстан Республикасының Конституциясы, 1, 13 бап, https://adilet.zan.kz/kaz/docs/K950001000_
[19] Қазақстан Республикасының Азаматтық Кодексі, Параграф 3., https://adilet.zan.kz/kaz/docs/K940001000_#z12
[20] Қазақстан Республикасының мемлекеттік қызметі туралы, 7-тарау., 8-тарау., https://adilet.zan.kz/kaz/docs/Z1500000416
[21] Әкімшілік құқық бұзушылық туралы Қазақстан Республикасының Кодексі, 40, 41,42,43,44 бап, https://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235
[22] Қазақстан Республикасының Қылмыстық кодексі, https://adilet.zan.kz/kaz/docs/K1400000226

- Төрийн байгууллагын хариуцлага: Төрийн байгууллагын албан тушаалтны хууль бус үйлдлээс үүдэлтэй хохирлыг нөхөн төлөхийн тулд албан тушаалтанд хариуцлага тооцох журмыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой зөрчилд хариуцлага хүлээлгэх гэх мэт.
- Шүүхэд хандах: Иргэн, аж ахуйн нэгж хохирлоо нөхөн төлүүлэхийн тулд шүүхэд хандан гомдол, нэхэмжлэл гаргаж шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой.
- Иргэнийг мэдээ, мэдээллээр хангах: Төрийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэдэд мэдээлэл өгөх замаар хохирогчдыг мэдээллээр хангах үүрэгтэй байна.

Эдгээр механизмууд нь тус улсын хууль эрх зүйн системд иргэн, аж ахуйн нэгжийн эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хүрээнд хамаарч байна.

### Хохирол нөхөн төлөх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд

Судлаачдын тэмдэглэснээр, Казахстан Улсын хууль эрх зүйн системд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс иргэн, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах бэрхшээлүүд тулгардаг байна. Үүнд:

- **Авлига:** Авлигын асуудал нь төрийн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх, шүүхийн шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж, хохирогчдын эрхийг зөрчих нөхцөл бий болгож байна.
- **Шүүхийн системийн ачаалал:** Шүүхийн систем хэт их ачаалалтай байгаа нь хохирогчид хохирлоо нөхөн төлүүлэхэд удаан хугацаа зарцуулж, шийдвэр гарах хүртэл хүлээх, цаг алдах байдлыг үүсгэж байна.
- **Мэдээлэл дутмаг байх:** Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байдал нь хохирогчид эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулж байна.
- **Төрийн байгууллагуудын хариуцлагагүй байдал:** Зарим төрийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлагаа ухамсарлахгүй байх, хууль бус шийдвэр гаргах, шийдвэр хэрэгжүүлэхгүй байх тохиолдол байна.
- **Хууль зүйн үйлчилгээний хүртээмж:** Хууль зүйн үйлчилгээ, зөвлөгөө авах зардал өндөр, үйлчилгээний хүндрэлтэй байдал нь хохирогчийг шүүхэд хандахад саад болдог.
- **Зарим хууль тогтоомжийн тодорхойгүй байдал:** Хууль тогтоомжийн тодорхойгүй, эсхүл зөрчилдөөнтэй заалтууд нь хууль хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулдаг.
- **Нийгмийн сэтгэлгээ:** Иргэдийн хууль, шүүхийн системд итгэх итгэл алдарч байгаа нь хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, энэ ажиллагаанд оролцохоос зайлсхийхэд хүргэж байна.

Эдгээр бэрхшээлүүд нь Казахстан Улсын хууль, эрх зүйн системийн үр дүнтэй үйл ажиллагаанд саад учруулж, иргэдийн эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг хэрэгжүүлэхэд бодитой хүндрэл учруулж байна гэж зарим судлаачид үзсэн байна.

### 4. Япон Улс

Өнөөгийн Япон Улс нь Үндсэн хуульт хаант засагт улс бөгөөд улс төрийн тогтолцооны үндэс нь 1947 оны Үндсэн хуулиар тодорхойлогддог. Энэ үндсэн хуулиар Япон Улсын тусгаар тогтнол, хүний эрх, төр засгийн удирдлага, орон нутгийн бие даасан байдлыг тэнцүүлэх зарчмыг тодорхойлжээ.

Япон Улс нь төрийн албан хаагчийн буруу шийдвэр, эрх мэдлээ урвуулан ашигласан болон төрийн алдаатай буруу үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан гэм хор, хохирлыг төлж барагдуулах хууль эрх зүйн зохицуулалтыг Япон Улсын **Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд** "Хүн бүр хохирлоо барагдуулах, төрийн албан тушаалтныг огцруулах, хууль, захирамж, журам батлуулах, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг бусад асуудлаар тайван замаар өргөдөл гаргах эрхтэй, мөн өргөдөл гаргасан гэж хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй" гэж; **17 дугаар зүйлд** "Хүн бүр төрийн аливаа албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлоо төлүүлэхээр төрийн болон нийтийн байгууллагад хандан нэхэмжлэл гаргах эрхтэй" гэж тус тус заасан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 1947 онд Төрийн нөхөн төлбөрийн тухай хууль (State Redress Act)[23] батлагджээ.

### Төрийн нөхөн төлбөрийн тухай хууль

Уг хууль нь 6 зүйлтэй. Хуульд төрийн болон олон нийтийн байгууллагын төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа бусдад санаатай буюу санамсаргүй байдлаар хохирол учруулсан бол хохирлыг төр, олон нийтийн байгууллага нөхөн төлөх үүрэгтэй гэж заасан байна. Төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа санаатай буюу илт болгоомжгүй үйлдэл гаргасан бол төрийн болон олон нийтийн байгууллага нь төрийн албан хаагчаас нөхөн төлбөр гаргуулах эрхтэй. Хохирлыг нөхөн төлсөн байгууллага нь дотооддоо учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, нөхөн төлбөр шаардах эрхтэй тухай хуульд тусгаж өгчээ. Мөн хохирол учруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Иргэний хууль (Civil Code)[24]-аар зохицуулна гэж хуулийн 5 дугаар зүйлд заасан байна.

### Иргэний хууль

Япон Улсын Иргэний хууль нь (1896 он) эртний хуулиудын нэг бөгөөд хамгийн сүүлд 2021 онд шинэчлэн найруулсан байна. Хууль 5 бүлэг, 724 зүйлтэй. Хуулийн II бүлгийн 8 хэсэгт хөдөлмөр эрхлэлтийн талаар, V бүлэгт гэм буруутай үйлдэлд хариуцлага тооцох асуудлын талаар тусгажээ. Үүнд:

- **628 дугаар зүйлд**, Талууд ажиллах хугацааг заасан байсан ч хүндэтгэх үзэх шалтгаан байвал аль нэг тал гэрээгээ нэн даруй цуцалж болно. Ийм тохиолдолд аль нэг талын хайхрамжгүй байдлаас шалтгаалан нөгөө талд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлүүлэх үүрэгтэй гэж;
- **709 дүгээр зүйлд**, Бусдын эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг санаатай буюу санамсаргүйгээр зөрчсөн этгээд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй гэж;
- **710 дугаар зүйлд**, Бусдын бие, эрх, эрх чөлөө, нэр төрд халдсан, эсхүл эд хөрөнгөд халдсан эсэхээс үл хамааран хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй гэж;
- **715 дугаар зүйлд**, Тодорхой бизнес эрхлэхийн тулд өөр хүнийг ажиллуулж байгаа этгээд ажилтнаас гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. Ажилтан ч гэсэн учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ гэж тус тус заасан байна.

### Төрийн албаны хууль тогтоомж

Япон Улсад төрийн албан хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гаргасан санаатай болон санамсаргүй хууль бус үйлдлийн улмаас бусдад хохирол учруулсан бол учирсан хохирлыг тооцох, хариуцлагын асуудлуудыг дээр дурдсан хууль тогтоомжуудаар зохицуулсан ба нийтлэг чиг үүрэг, хариуцлагын асуудлыг Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм зэрэгт нарийвчлан

[23] State Redress Act, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3785/en#je_at2
[24] Civil Code, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4314

зааж өгсөн байна. Тухайлбал, Японы **Төрийн албаны тухай хууль** (National Public Service Act)[25]-ийн 82 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ажил үүргээ гүйцэтгэж байхдаа үүргээ зөрчсөн, эсхүл үүргээ умартсан бол сахилгын шийтгэл ногдуулж, ажлаас нь чөлөөлж, үүрэгт ажлаас нь түдгэлзүүлж, цалин хөлсийг бууруулж, сануулга өгч болно.” гэсэн байна.

Япон Улс нь **Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль** (National Public Service Ethics Act)-ийг 1999 онд баталсан бөгөөд тус хуулийг бүрэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэх Төрийн албаны Ёс зүйн хороо (National Public Service Ethics Board)-г Эзэн хааны ивээл дор байгуулжээ. Тус Ёс зүйн хороо нь төрийн албан хаагчид ёс зүйн хуулийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх сургалт, семинар, гарын авлага гаргах ба төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, хяналтыг бүх шатанд тогтмол хийж олон нийтэд танилцуулахаас гадна олон нийтээс санал асуулга, гомдол, хүсэлт тогтмол хүлээн авч ажилладаг байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг үндэслэн Япон Улсын Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тушаалаар **Төрийн албаны үндэсний ёс зүйн дүрэм** (National Public Service Ethics Code)-ийг баталсан байна. Дүрмийн зорилгод Ажилтан нь төрийн албан хаагч гэдгээрээ бахархаж, өөрсдийн эрхэм зорилгыг ухамсарлаж Төрийн албаны ёс зүйн тухай хуульд заасан зарчмуудыг баримталж, мөрдөж ажиллахад чиглэнэ гэжээ.

Япон Улсын төрийн албыг Азийн хамгийн анхны мерит зарчимд суурилсан төрийн алба гэж үздэг. Тус улсын мерит тогтолцооны онцлог нь төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэхдээ маш нарийн сонгон шалгаруулалтын системийг ашигладагт оршино. Япон Улсын төрийн албаны тогтолцоо нь нээлттэй, мерит зарчимд суурилсан учраас төрийн алба нь улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой, амжилтаараа зэрэглэл ахих системтэй. Төрийн албан хаагчдыг бүх насаар гэрээ байгуулан ажиллуулах тогтолцоо нь тэдгээрийг салбар хооронд шилжих явдлыг багасгаж, ихээхэн тогтвор суурьшилтай ажиллах бололцоог бүрдүүлснээр орон тооны хувьд цомхон, төрийн албан хаагчдын чадварлаг баг ажиллуулах боломжтой болгодог байна.

[25] National Public Service Act, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/1917/en#je_ch3sc6sb2

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Вьетнам

- Constitution, https://www.moj.gov.vn/vbpq/en/Lists/Vn%20bn%20php%20lut/View_Detail.aspx?ItemID=10450
- On State compensation liabilty law, https://www.moj.gov.vn/vbpq/en/lists/vn%20bn%20php%20lut/view_detail.aspx?itemid=10465
- https://thuvienphapluat.vn/van-ban/EN/Tai-chinh-nha-nuoc/Circular-no-03-2013-TT-BTP-guidelines-for-the-state-management-on-compensation/173965/tieng-anh.aspx

Герман

- Германы Иргэний хууль https://www.gesetze-im-internet.de/bgb/__839.html
- ХБНГУ-ын Үндсэн хууль, https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html#p0172
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль., https://www.gesetze-im-internet.de/streg/BJNR001570971.html

Казахстан

- Қазақстан Республикасының Азаматтық Кодексі, https://adilet.zan.kz/kaz/docs/K940001000_#z12
- Қазақстан Республикасының Конституциясы, https://adilet.zan.kz/kaz/docs/K950001000_#z7
- Қазақстан Республикасының Үкіметі туралы, https://adilet.zan.kz/kaz/docs/Z950002688_
- Қазақстан Республикасының мемлекеттік қызметі туралы, https://adilet.zan.kz/kaz/docs/Z1500000416
- Әкімшілік құқық бұзушылық туралы Қазақстан Республикасының Кодексі, https://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235

Япон

- The Constitution of Japan, https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html
- State Redress Act, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3785/en#je_at2
- Civil Code, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4314
- National Public Service Act, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/1917/en#je_ch3sc6sb

Бусад

- Хохирлын сангийн тухай гадаад орнуудын харьцуулсан судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн
- Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал, ХЗҮХ-ийн судалгааны тайлан
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, https://legalinfo.mn/mn/detail/1271
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, https://legalinfo.mn/mn/detail/1257
- Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power, https://www.unodc.org/pdf/rddb/CCPCJ/1985/A-RES-40-34.pdf